

## НИЙГМИЙН БОДЛОГО ДАХЬ НИЙГМИЙН ХАМГААЛАЛ БА НИЙГМИЙН ХАЛАМЖ

*Б. Бат-Өлзий  
Доктор (Ph. D.)*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль  
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

*bbatulzii04@gmail.com*

*Б. Болормаа  
Доктор (Ph. D.)*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль  
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

*bumbaalai8888mn@yahoo.com*

**Хураангуй:** Энэхүү өгүүлэлд нийгмийн бодлогын бүрэлдэхүүн дэхь нийгмийн хамгаалал ба нийгмийн халамжийн уялдаа холбоо хамаарлын асуудлыг авч үзлээ. Сүүлийн жилүүдэд манай орны нийгмийн хамгааллын салбар тэр дундаа халамжийн салбарыг шүүмжлэх шүүмжлэл нийгэмд ихээхэн газар авч байна. Тиймээс асуудлыг ойлголт, агуулгын түвшинд зөв тодорхойлох шаардлагатай гэж үзэж байна.

**Түлхүүр үгс:** Нийгмийн бодлого, нийгмийн хамгаалал, халамж, нийгмийн ажил

### ҮНДСЭН ХЭСЭГ

Нийгмийн бодлого хэмээх ойлголтыг тодорхойлохын өмнө “бодлого гэж юу?” гэсэн ерөнхий асуултанд хариулт эрье. Андерсоны <sup>28</sup> тодорхойлсоноор төрийн бодлого бол:

- *Эрх мэдэл бүхий засгийн газрын үйл ажиллагаа.* Төрийн бодлого нь эрх зүй, улс төр ба санхүүгийн эрх мэдэл бүхий засгийн газраас гүйцэтгэх үйл ажиллагаа мөн.
- *Бодит байдлын хэрэгцээ буюу асуудалд хандах.* Төрийн бодлого нь нийгэм, нийгмийн бүлэг хүмүүс, тухайлбал иргэд, төрийн ба төрийн бус байгууллагуудын тодорхой хэрэгцээ, асуудалд хариулахыг эрмэлздэг.
- *Зорилгод баримжаалсан.* Төрийн бодлого нь тухайн зорилтот бүлгийн тодорхой хэрэгцээг хангах юмуу эсвэл түүнийг

---

<sup>28</sup> Anderson, James E. (1994) *Public policymaking*. New Jersey: Houghton Mifflin

шийдвэрлэх оролдлогыг төлөөлж чадах сайтар бодолцсон зорилтуудад хүрэхийг эрэлхийлдэг.

- *Үйл ажиллагааны чиг.* Төрийн бодлого нь цорын ганц шийдвэр, үйлдэл буюу хариу үйлдэл биш, харин сайтар боловсруулсан арга барил, стратеги юм.
- *Ямар нэгэн зүйл хийх, эсвэл юу ч хийхгүй байх шийдвэр.* Боловсруулсан бодлого нь асуудлыг шийдэхийг оролдон арга хэмжээ авдаг, эсвэл тухайн үеийн бодлогын хүрээнд энэ асуудал шийдэгдэнэ хэмээн үзэж арга хэмжээ авдаггүй.
- *Нэг буюу хэд хэдэн субъектийн үйл ажиллагаа болох нь.* Бодлого нь төрийн нэг төлөөлөл буюу байгууллага, эсвэл хэд хэдэн оролцогчоор дамжин хэрэгжиж болно.
- *Үйл ажиллагааны үндэслэл.* Бодлого нь бодлогын цаана байгаа учир шалтгааныг гол төлөв тусгадаг.
- *Шийдвэр гаргах.* Бодлого нь аль хэдийн гаргасан шийдвэр болохоос хийх гэж буй санаа буюу амлалт биш юм.

Тэгвэл төрийн бодлогын нэг хэсэг болох “нийгмийн бодлого” гэж юу вэ? Жочэн, Класэн нар хувь хүмүүсийн амьдралын чанар, сайн сайхныг бүрдүүлэхийг зорьсон, тийм нийгмийн орчныг бүрдүүлэхийг эрмэлзсэн, төрийн бодлогыг нийгмийн бодлого гэж үзэж болно<sup>29</sup>.

Нийгмийн бодлого гэдэг нь нийт иргэдийнхээ чинээлэг хангалуун амьдрал, хөдөлмөр, амьдралын нөхцлийг дээшлүүлэхэд чиглэсэн нийгэм, төрийн үйл ажиллагаа<sup>30</sup>.

Нийгмийн бодлого нь тодорхой бүтэц бүхий тогтолцоо бөгөөд түүний бүхэллэг шинж нь *нэгдүгээрт*, нийгмийн хөгжлийн стратегийн зорилго, зорилтуудын сонголт, хандлага, *хоёрдугаарт*, хүн амын бүхий л давхрага, хүрээг бүрэн хамарсан нэгдмэл эрх зүйн зохицуулалт, *гуравдугаарт*, төр болон бусад субъектүүдээс нийгмийн бодлогын хэрэгжилтийг хангах санхүүжилт, *дөрөвдүгээрт*, нийгмийн нэгдмэл дэд бүтэц, хүний нөөц, мэдээллийн сүлжээгээр тус тус тодорхойлогдоно. Нийгмийн бодлого нь олон түвшинтэй, тогтолцоолог шинжтэй. Эдгээр нь:

- Нийгмийн хамгаалал;
- Боловсрол, эрүүл мэнд, соёл, спорт, аялал жуулчлал, орон сууцны хангамж;
- Хөдөлмөрийн зах зээл, ажил эрхлэлт, ажилгүйдэл;
- Хөлс төлөлт, хөдөлмөр хамгаалал;
- Нийгмийн түншлэл;

---

<sup>29</sup> Jochen, Clasen (2004) *Defining comparative social policy. In Kennet Patricia A Handbook of Comparative Social Policy, Edward Elgar Publishing*

<sup>30</sup> С.Түмэндэлгэр (2002) *Нийгмийн ухааны зарим нэр томъёоны тайлбар, УБ*

- Нийгмийн даатгал;
- Нийгмийн халамж;
- Тэтгэврийн тогтолцоо зэрэг нь бүгд нийгмийн бодлогын хүрээнд хэрэгжинэ<sup>31</sup>.

Нийгмийн бодлого нь социаль хүрээг удирдах төрийн зорилго чиглэлтэй үйл ажиллагаа юм. Нийгмийн социаль хүрээ нь хүний амьдралын үндсэн суурь хэрэгцээнүүдийг хангахад чиглэнэ. Ийм агуулгаар авч үзвэл нийгмийн бодлогын гол эрхэмлэл нь хүн бүрийн амьдралын чанар, түвшний талаарх анхаарал халамж юм<sup>32</sup>.

Нийгмийн бодлого<sup>33</sup>:

- Нийгмийн бодлого бол төрийн бодлогын үндсэн чиглэл мөн;
- Нийгмийн бодлого нь нийгмийн сайн сайхны (well-being) төлөө төр засгийн зүгээс явуулж буй арга хэмжээ, үйл ажиллагааны тогтолцоо мөн;
- Нийгмийн бодлого нь хүний өдөр тутмын амьдралын дор бүрэлдэн буй нөхцөл байдал болох нийгмийн харилцаанд хөндлөнгөөс оролцох төрийн үйлдэл мөн;
- Нийгмийн бодлого нь төр ба нийгмийн харилцан зохирох огтлол хэсэг бөгөөд нийгмийн дэд системийг зохицуулахад чиглэсэн улс төрийн системийн арга хэрэгсэл мөн;
- Нийгмийн бодлого нь нийгмийн асуудал болон нийгмийн эрсдлийг угтан хариу үйлчлэл үзүүлэхэд чиглэдэг. Нийгмийн асуудлын төрөл, хүндрэлтэй тал, үргэлжлэх хугацаа, хэр хэмжээ, тулгамдсан байдал нь нийгмийн бодлогын хэрхэн хэрэгжих үндэслэл болдог;
- Нийгмийн бодлого нь эдийн засаг хийгээд нийгмийн амьдралд гүйцэтгэх ардчилсан төрийн үүрэг, оролцоог тэмдэглэсэн ойлголт бөгөөд зах зээлийн эдийн засаг, капитализмтай нэгэн зэрэг нийгмийн тэнцэтгэлийн (тэгш байдлын) зарчмыг нарийн уялдуулан хослуулсан түүхэн нийгмийн үзэгдэл мөн;
- Нийгмийн бодлого нь төрийн зүгээс баримжаалдаг боловч, янз бүрийн үйлчилгээ, арга хэмжээ, үйл ажиллагаанд бэлтгэгдсэн олон тооны байгууллагууд, институцууд, оролцон тоглогчдын хамтын үйлдлийн үр дүнд оршин байдаг.

Зах зээлийн нөхцөлд нийгмийн хангамжийн тогтолцоог бүрдүүлэх арга замаар хүн амын олонхийн амьдралын түвшинг дээшлүүлэхийн тулд орлогын хуваарилалт хийгдэнэ. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн тэнцвэрээр тогтоодог цалин хөлсийг хүмүүст олгохоос

<sup>31</sup> Н.Наранчимэг, П.Увш, Н.А.Волгин (2009), *Нийгмийн бодлого, УБ*

<sup>32</sup> Н.Наранчимэг, П.Увш, Н.А.Волгин (2009), *Нийгмийн бодлого, УБ*

<sup>33</sup> НХХЯ, ХХҮГ (2008), *Нийгмийн ажилтны сургалтын гарын авлага, УБ*

гадна “хүн амьд явах, чанартай амьдрах” үндсэн эрхийг эдлүүлэхэд нийгмийн орлогын зарим хэсгийг хуваарилах, дахин хуваарилах замаар орлогын хуваарилалтанд төр оролцдог. Энэхүү цогцолбор механизмыг “төрийн нийгмийн бодлого” гэнэ. Энэ бодлого нь 1). Хүн амын янз бүрийн давхрааны хооронд болон дотоодод ч зохистой харьцааг бүрдүүлэх, 2). Нийгмийн гишүүдийн амьдралын түвшин, аж байдлыг дээшлүүлэх, 3). Хүн амын нийгмийн баталгааг хангахын хамт бололцоотой хүн бүхэн нийгмийн нийгмийн үйлдвэрлэлд идэвхитэй оролцох эдийн засгийн хөшүүрэг болно.<sup>34</sup>

Нийгмийн социаль хүрээний хөгжилд нөлөөлөх, зохицуулах үүднээс төрийн болон улс төр, захиргааны байгууллагуудын чиглэсэн зорилготой, цогц үйл ажиллагаа. Орчин үед улс төрийн намууд, төр засгийн байгууллага үндсэн үзэл баримтлал, мөрийн хөтөлбөрөө боловсруулахад нийгмийн бодлогыг бие даасан чиглэл болгон онцгой анхаардаг. Нийгмийн бодлогын чиглэх гол объект нь хүн, хүний хөгжлийн асуудлууд юм. Иргэн бүр чинээлэг хангалуун амьдарч ажиллах бүх талын боломж бололцоог хангах нь нийгмийн бодлогын стратегийн гол зорилго байдаг. Нийгмийн бодлогын хүрээнд юуны өмнө боловсрол, соёл, шинжлэх ухаан, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурал зэрэг үндсэн асуудал хамаарна. Нийгмийн бодлого нь арьсны өнгө, яс үндэс, угсаа гарвал, шашин шүтлэг, хөрөнгө чинээ, боловсрол мэдлэг, албан тушаалын зэрэг дэв зэргээс үл хамааран хүн амын бүх бүлэг, давхрааг хамран хэрэгждэг. Ингэхдээ хүн амын тодорхой бүлэг давхрааны онцлогийг харгалзан тооцсон байдаг. Нийгмийн бодлогыг боловсруулж, нэн тэргүүний шийдвэрлэх зорилтыг дэвшүүлэх, шийдлийн зөв хувилбарыг сонгоход бодлого боловсруулагчдад нийгмийн шинжлэх ухаан, ялангуяа нийгмийн ажил, бодлогын судалгаа чухал дэм туслалцаа үзүүлдэг.

**Нийгмийн хамгаалал** (Social protection), нийгмийн халамж (Social welfare) гэсэн ойлголтуудын уялдаа холбоог тайлбарлахдаа ихэнх судлаачид нийгмийн хамгаалал нь илүү өргөн ойлголт бөгөөд нийгмийн халамж нь түүний нэгээхэн бүрдэл хэсэг гэж үздэг. Гэвч энэ хоёр ойлголт нь үндсэн зарчмаараа ялгаатай гэдгийг онцолдог. Нийгмийн хамгаалал нь тухайн улсын нийт иргэдийн амьдрах, үйлдвэрлэл болон хөдөлмөр эрхлэх, амрах, хөгжих бүх бололцоог бий болгох улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүйн нөхцлийг бүрдүүлэх зорилт тавьдаг бол нийгмийн халамж нь бие даан амьдрах чадваргүй, нийгмийн зүгээс зайлшгүй тусламж дэмжлэг шаардсан хүмүүсийн амьдралын наад захын хэрэгцээг хангах, тусламж, дэмжлэг

---

<sup>34</sup> Нээлттэй Нийгэм форум, UNDP (2006) Ардчилсан засаглал, нээлттэй нийгмийн нэр томъёоны тайлбар толь, УБ

үзүүлэхэд чиглэгддэг. Нийгмийн хамгаалал гэдэг нь нийт хүн амыг хамардаг бол нийгмийн халамжид ядарч зүдэрсэн эмзэг хэсгийн хүмүүс хамаарна<sup>35</sup>. Мөн нийгмийн хамгаалал нь өмчлөл, хөрөнгө оруулалт, цалин хөлс, татвар, зээл, шимтгэл зэрэг эрх зүй, санхүү, эдийн засаг, нийгмийн харилцааны механизмуудаар дамжиж хэрэгждэг бол нийгмийн халамж нь тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, асрамж, халамжийн үйлчилгээ гэсэн хэрэглээний арга, механизмаар хэрэгжиж байдаг<sup>36</sup>.

Нийгмийн хамгааллыг өргөн ба явцуу агуулгаар ойлгож, хэрэглэх хандлага судлаачид, улс орнуудын нийгэм, эдийн засгийн тогтолцоо, хөгжлийн түвшингээс хамааран өөр өөр байна. Тухайлбал оросын эрдэмтэн Л.С. Ражаницына “Нийгмийн хамгаалал бүх хүн амыг хамаарна” гэж байхад, судлаач Е.Г. Берницкая “Хүн амын эмзэг давхраануудыг хамрах ёстой” гэж үзжээ<sup>37</sup>. Мөн хөрөнгө, санхүүгийн хязгаарлагдмал нөөцтэй, буурай хөгжилтэй улс орнуудын хувьд нийгмийн хамгааллын бодлогоо ингэж явцуу хүрээнд тодорхойлох хандлагатай байдаг.

Судлаач Ч.Дагвадорж нийгмийн хамгааллыг өргөн ба явцуу аль аль талаас нь тодорхойлсон. Өргөн утгаараа “Нийгмийн хамгааллын систем гэж хүмүүнлэг, соёл иргэншилт нийгмийн гишүүн бүрийн ажил эрхлэлт, боломжит цалин хөлс, чинээлэг хангалуун амьжиргаа, олон ургальч үзэл, ардчилал, байгаль орчны хамгааллын асуудлуудыг багтаасан нийгэм, улс төр, эдийн засаг, эрх зүйн харилцааны цогц арга хэмжээг хэлнэ” гэсэн бол явцуу утгаараа “Амьдралын явцад өтлөлт, осол, өвчлөлд өртөж хөдөлмөрийн чадвараа алдсан иргэд болон өнчин хүүхэд, бие, эрхтний эмгэгтэй хүмүүс, хүүхэд төрүүлсэн, олон хүүхэдтэй, бэлэвсэрсэн, орлогогүй гэр бүлд амьдралын бололцоо олгоход чиглэсэн тэтгэмж, тэтгэвэр олгох, асрамжлах, халамжлах үйлчилгээг нийгмийн хамгаалал” гэж тодорхойлжээ<sup>38</sup>.

НҮБ, Дэлхийн банк зэрэг Олон улсын байгууллагууд ч нийгмийн хамгааллыг өргөн утгаар нь тодорхойлсон байдаг. Нийгмийн хамгаалал гэдэг нь ард түмний сайн сайхан байдалд сөргөөр нөлөөлөх нөхцөлийг даван туулах, урьдчилан сэргийлэх, удирдах, нийгмийн хөгжлийг хангах явдал гэж НҮБ-ын эрдэм шинжилгээний хүрээлэнгээс тодорхойлсон байна<sup>39</sup>.

Нийгмийн хамгаалал нь үр ашигтай хөдөлмөрийн зах зээлийг дэмжих, эрсдэлд буй хүмүүсийн эрсдэлийг бууруулж, ажилгүйдэл,

---

<sup>35</sup> Г.Оюунцэцэг, Ч.Дагвадорж (2003) *Нийгмийн халамжийн удирдлага*. УБ

<sup>36</sup> Г.Оюунцэцэг, Ч.Дагвадорж (2003) *Нийгмийн халамжийн удирдлага*. УБ

<sup>37</sup> Ч.Дагвадорж (1993) *Социальная защита населения в условиях рыночных отношений*. Диссертация на соискание учёния степени кандидата экономических наук. Москва

<sup>38</sup> Ч.Дагвадорж (2004) *Нийгмийн хамгаалал: онол-арга зүй, туршлага, харьцуулалт*. УБ

<sup>39</sup> United Nations Research Institute for Social Development (2010). *Combating Poverty and Inequality: Structural Change, Social Policy and Politics*

нийгмийн гадуурхал, өвчлөлт, хөгжлийн бэрхшээл, насжилт зэрэг нийгэм, эдийн засгийн эрсдлийг удирдах, иргэдийн чадавхийг дэмжих замаар ядуурал, эмзэг байдлыг бууруулах зорилготой бодлого, хөтөлбөрүүдээс бүрдэнэ<sup>40</sup> гэж Дэлхийн банк тодорхойлсон байна.

Иргэд, удирдлагын бүх шатны байгууллагуудын хуулиар баталгаажсан нийгэм, эдийн засгийн баталгааг хэрэгжүүлэх арга хэрэгслийн тогтолцоо, нийгмийн хөгжлийн тодорхой нөхцөл байдалтай уялдуулан хүн амын амьжиргааг зохистой хэмжээ, тодорхой төвшинд хүргэхэд туслаж буй механизм юм. Нийгмийн хамгаалал нь хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэх, нийгэм-эдийн засаг, эрхийн баталгаа болдог. Энэ нь иргэдийн амьдралын зохистой чанар, амьжиргааны түвшинг хангахад тусалдаг<sup>41</sup>.

Монгол Улсын төр, засгаас хүн амын нийгмийн хамгааллын баталгааг хангах бодлогыг “нийгмийн даатгал”, “нийгмийн халамж” гэсэн үндсэн хоёр дэд бүтцийн хүрээнд хэрэгжүүлдэг<sup>42</sup>.

Нийгмийн халамж нь нийгмийн даатгал, тухайлбал ажилгүйдлийн тэтгэмж болон ахмад настны тэтгэврийн даатгал зэрэг нийгмийн хамгааллын бусад асуудлаас ялгаатай<sup>43</sup>.

Дээрх тодорхойлолтууд болон үзэл баримтлалуудаас дүгнэвэл “нийгмийн хамгаалал” нь “нийгмийн халамж”-ийг өөртөө багтаасан, илүү өргөн ойлголт юм. Нийгмийн хамгаалал ба нийгмийн халамж нь төрийн болон нийгмийн бодлогын дор хэрэгждэг, түүний үндсэн бүрэлдэхүүн хэсэг нь юм. Үүнийг дараах байдлаар схемчлэн харуулж байна (Зураг 1).

*Зураг 1: Төрийн тогтолцоон дахь нийгмийн халамж*



<sup>40</sup> World bank (2001) Social Protection Sector Strategy Paper: From Safety Net to Springboard. Washington DC, USA

<sup>41</sup> Нээлттэй Нийгэм форум, UNDP (2006) Ардчилсан засаглал, нээлттэй нийгмийн нэр томъёоны тайлбар толь, УБ

<sup>42</sup> Ц.Бумхорол (2000) Нийгмийн бодлогын зарим асуудлууд. УБ

<sup>43</sup> Margaret Grosh, Carlo del Ninno, Emil Tesliuc, and Azedine Ouerghi, “For Protection and Promotion The Design and Implementation of Effective Safety Nets” World Bank, Washington, D.C. 2008

“Social welfare” гэсэн ойлголтын эх утга нь сэтгэл хангалуун, хөгжин цэцэглэсэн, сайн сайхан нийгмийн төлөв байдлыг илэрхийлдэг өргөн ойлголт боловч орчин цагт “**төрөөс үзүүлэх нийгмийн халамж**” гэж ойлгох хандлага давамгайл болсон.<sup>44</sup> Түүхийг эргэн харвал төр иргэдийнхээ сайн сайхан байдлыг хангахад чухал үүрэгтэй оролцох болсон нь тийм ч эртний зүйл биш юм. Уламжлалт нийгэмд хүмүүс өөрсдөө эсвэл гэр бүлийнхээ дэмжлэгтэйгээр амьдралд тохиолдсон аливаа төвөгтэй асуудлаа шийдвэрлэж, амьдралынхаа сайн сайхан байдлыг бий болгодог байсан. Үүний хажуугаар ихэнх нийгэмд соёл, зан заншил, уламжлалаасаа хамаараад хамаатан садан, ах дүүгийн холбоо, хөрш хүмүүс, найз нөхөд, сайн санаат хүмүүсийн харилцан туслалцах системүүд хүчтэй байжээ. Зарим үндэстнүүдийн хувьд шашны зан үйл нь ийм систем бий болоход гол үүрэг гүйцэтгэж, шашны өглөг хандив, буяны байгууллагууд бий болсон байдаг. Аажимдаа зохион байгуулалтын хэлбэрт орсон өглөг хандив, тусламжийн байгууллагууд нь “нийгмийн ажил” үүсч хөгжих эх суурийг тавьсан төдийгүй нийгмийн сайн сайхан байдлын төлөө ядуус, нийгмийн эмзэг бүлэгт туслах, тэднийг дэмжих төрийн оролцоог ч бий болгосон юм.<sup>45</sup>

Орчин үед ядуу, эмзэг бүлгийн сайн сайхан байдлыг хангахын төлөөх чиг хандлагыг i) филантропи, ii) нийгмийн ажил, iii) нийгмийн халамж гэж гурван чиглэлд хуваан үздэг.<sup>46</sup>

**Филантропи** нь тусламж хэрэгтэй хүмүүст шаардлагатай эд материал, үйлчилгээ хүргэх замаар тэдний сайн сайхан байдлыг бий болгохыг оролддог. Филантропи нь өнө эртнээс эх үүсвэртэй, ихэвчлэн хувь хүмүүс шашны итгэл үнэмшилдээ хөтлөгдөн буян үйлдэх замаар нийгмийн сайн сайхан байдалд хувь нэмрээ оруулсаар ирсэн байдаг. Яваандаа филантропи нь дан ганц хувь хүмүүсийн өглөг буяны үйлээс хүрээгээ тэлж, зохион байгуулалттай, байгууллагын үйлчилгээний хэлбэрээр хүмүүст тусламж үзүүлэх арга хэрэгсэл болон хөгжсөн. Өвчтэй хүмүүсийг асрах, орон гэргүй хүүхдүүд болон ядууст хоол, хувцас, орон байраар үйлчлэх болон бусад материаллаг тусламжуудыг үзүүлэх нь филантропийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр юм. Орчин цагт филантропи үйл ажиллагааг шашны байгууллагууд төдийгүй шашны бус байгууллагууд ч явуулж байна. Филантропи үйл ажиллагаа нийгмийн тодорхой бүлэгт, тодруулж хэлбэл өөрөө өөртөө туслах бололцоо

---

<sup>44</sup> James Midgley (1995) *Social Development: The Development Perspective in Social Welfare. The Journal of Sociology & Social Welfare. Volume 23: Iss. 3*

<sup>45</sup> Нийгмийн хөгжлийн төв, УБИС-ийн НА тэнхим (2002) *Нийгмийн хөгжлийн хандлагатай нийгмийн ажил. Нийгмийн ажлын багш нарын зуны сургалтын материал*

<sup>46</sup> James Midgley (1995) *Social Development: The Development Perspective in Social Welfare. The Journal of Sociology & Social Welfare. Volume 23: Iss. 3*

чадваргүй хүмүүст чиглэгддэг. Филантропийн хөгжил нь өглөг хандив өгөх хүмүүсийн өгөөмөр сэтгэлээс гадна тэрхүү өглөг хандивыг татвараас чөлөөлөх төрийн бодлого зохицуулалтаас их хамаардаг.

**Нийгмийн ажил** нь зохион байгуулалттайгаар, мэргэжлийн боловсон хүчний тусламжтайгаар нийгмийн асуудлыг шийддэг чиг хандлага юм. Нийгмийн ажил нь XIX зууны сүүлийн хагаст үйлдвэржсэн орнуудад үүсч хөгжсөн. Тэр цагаас хойш нийгмийн ажлын хүрээ өргөжин, мэргэжлийн хувьд асар хурдацтай хөгжиж байна. Нийгмийн ажлын гол онцлог бол хувь хүн, бүлэг, олон нийтийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхдээ мэргэжлийн үйл ажиллагаан дээр тулгуурладаг. Нийгмийн ажилтнуудыг мэргэжлийн сургуулиудаар бэлтгэж, мэргэжлийн боловсрол олгодог. Сургалтын явцад хүний зан үйл, төлөвшилт, сэтгэл судлал болон нийгмийн асуудлын талаарх цогц мэдлэг боловсрол олж авдаг бөгөөд хувь хүн, бүлэг, олон нийтэд туслах, интервенц хийх арга барилд суралцдаг. Мөн үйлчлүүлэгчтэй шууд харьцах боломж олгодог нийгмийн үйлчилгээний байгууллагуудад мэргэжлийн супервайзер хүний удирдлага дор онолын мэдлэгтэй хосолсон дадлага ажил хийх замаар мэргэшдэг. Нийгмийн ажилтнууд дийлэнхдээ төрийн бус, ашгийн төлөө бус нийгмийн үйлчилгээний байгууллагуудад ажиллаж, мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг ч, улс орнуудын төв болон орон нутгийн засаг захиргааны харъяа байгууллагуудад, жишээлбэл сургуулийн нийгмийн ажил, эрүүл мэндийн салбарын нийгмийн ажил, хорихын нийгмийн ажил болон халамжийн байгууллагад ажиллах нь түгээмэл байна. Мөн өндөр хөгжилтэй орнуудад тухайлбал АНУ-д ашгийн төлөө хувийн секторт ажиллаж, хувийн зөвлөгөө өгөх үйлчилгээг төлбөртэй үзүүлэх практик ч байдаг.

**Нийгмийн халамж** нь төрөл бүрийн нийгмийн үйлчилгээг төрөөс үзүүлэх замаар нийгмийн гишүүдийнхээ, тэр дундаа ядуу, эмзэг хэсгийн амьдралын баталгааг хангахыг эрмэлздэг. Энэхүү чиг хандлагыг нийгмийн бодлогын (social policy) эсвэл нийгмийн үйлчилгээний (social service) арга ч гэж нэрлэдэг. Филантропи нь хувь хүмүүсийн өглөг хандивыг хамгийн их хэрэгцээтэй хүмүүст чиглүүлэхийг хичээдэг бол нийгмийн халамж нь нийтийн нөөц баялагийг (татвараар цугларсан төрийн хөрөнгө, мөнгө) тусламж шаардлагатай нийгмийн эмзэг бүлгүүдэд (өнчин хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, өрх толгойлсон олон хүүхэдтэй эмэгтэй ба эрэгтэй, ядуучууд гэх мэт) чиглүүлэхийг хичээдэг. Нийгмийн халамж нь төр иргэдийнхээ амьдралын сайн сайхан байдлыг бий болгох үүрэгтэй бөгөөд энэ үүргээ биелүүлэхийн тулд төрөл бүрийн нийгмийн үйлчилгээг бий болгох ёстой гэсэн үзэл санаан дээр суурилдаг.

Европт Английн хатан хаан I Элизаветийн<sup>47</sup> үед ядуучуудын тухай хууль гарсан явдлыг нийгмийн гишүүдийн сайн сайхан байдлыг хангахын тулд төрийн оролцоог бий болгосон анхны алхам гэж тооцдог. Гэхдээ үүнээс өмнө үеүдэд, тухайлбал эртний Вавилонд өнчин хүүхэд болон бэлэвсэн эхнэрүүдийн эрх ашгийг хамгаалдаг байсан тухай мэдээ байдаг. Ямар боловч Элизаветийн үед гарсан ядуучуудын тухай хууль нь өмнөх үеийнхээс төрийн оролцоог системтэй болгож өгсөн анхны хууль юм<sup>48</sup>. Тэгвэл Монгол улсын халамжийн тогтолцоо нь өнө эртний уламжлал, түүхтэй бөгөөд 1206 онд Их Монгол улсын үед өнчин ядуусыг тэтгэх ажил төрийн бодлогын хэмжээнд тавигдаж байсан байна. Өгөөдэй хаан өнчин ядуусыг тэтгэх, тэднээс алба татвар авахгүй байхыг зарлиг болгож, ядууст тусламж үзүүлэх сан байгуулж байжээ.<sup>49</sup>

Нийгмийн халамжийн чиг хандлага нь эдийн засгийн үйл ажиллагаатай шууд холбоотой. Нийгмийн халамжийн үйлчилгээнүүд нь төсвөөс буюу эдийн засаг, татварын орлогоос хамааралтай байдаг. Хэдийгээр эдийн засгийн өсөлт, хөдөлмөр эрхлэлт нь нийгмийн хөгжлийн зайлшгүй нөхцөл гэж үздэг ч, практик дээр нийгмийн халамж нь нийгмийн үйлчилгээнүүдийг эдийн засгаас тусад нь хөгжүүлж, нийгэм эдийн засгийн хөгжлийг хослуулахад тун бага хүчин чармайлт гаргадаг. Ихэнх үйлдвэржсэн орнуудад нийгмийн халамж эдийн засаг хоорондын харьцаа нь нэг нь нөгөөгөөсөө хамаарсан байдалтай байдаг. Нийгмийн халамж нь өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүйчүүд болон нийгмийн бусад эмзэг бүлгийн хүмүүсийг дэмжсэн нийгмийн үйлчилгээ үзүүлэх замаар тэдний амьдралын наад захын стандартыг хангахыг зорьдог. Нийгмийн халамж нь санхүүжилтийн хувьд эдийн засгаас бүрэн хамааралтай байдаг. Тухайлбал эдийн засаг хямралд орох үед нийгмийн халамжийг санхүүжүүлж байдаг орлого буурч төрийн нуруун дээрх дарамт ихэсдэг. Гэтэл эдийн засгийн хямралтай үед хүмүүст нийгмийн үйлчилгээ улам илүү хэрэгцээ шаардлагатай болдог.

Ийнхүү дээрх 3 чиглэл нь харьцангуй бие даасан, өөр хоорондоо ялгаатай ч, уялдаа холбоотой хэрэгждэг, олон шинжээрээ ижил төстэй юм. Нэн ялангуяа нийгмийн ажил ба нийгмийн халамжийн чиглэлүүд маш нарийн уялдаа холбоотойгоор үйл ажиллагаа явуулж байна. Өнөө цагт нийгмийн ажил нь нийгмийн халамжийн онол, арга зүйн үндэс болж, нийгмийн халамжийн үйлчилгээг мэргэжлийн нийгмийн ажилтнууд гүйцэтгэх болсон.

---

<sup>47</sup> 1558 онд Ангийн хатан хаанаар өргөмжлөгдөж, нас бартлаа буюу 1603 он хүртэл энэхүү албыг хашсан

<sup>48</sup> James Midgley (1995) *Social Development: The Development Perspective in Social Welfare. The Journal of Sociology & Social Welfare. Volume 23: Iss. 3*

<sup>49</sup> Г.Оюунцэцэг, Ч.Дагвадорж (2003) *Нийгмийн халамжийн удирдлага. УБ*

Нийгмийн халамж нь төрөл бүрийн нийгмийн үйлчилгээг төрөөс үзүүлэх замаар нийгмийн гишүүдийнхээ, тэр дундаа ядуу, эмзэг хэсгийн амьдралын баталгааг хангахыг эрмэлздэг гэсэн дээрх хандлагын зэрэгцээ түүнийг илүү өргөн хүрээнд авч үзсэн судлаачид байна. Тухайлбал судлаач Г.Оюунцэцэг, Ч.Дагвадорж нар нийгмийн халамж нь гурван талт, гурван бүрэлдэхүүнт, гурван зарчимт агуулгатай<sup>50</sup> гэж үзсэн. Нийгмийн халамжийн *гурван талт* гэдэг нь нийгмийн эмзэг хэсгийн хүн амын наад захын хэрэгцээг хангахад а) төр засаг, б) аж ахуйн нэгж, в) иргэд, хувь хүн бүр идэвхитэй оролцож байж үр дүнд хүрнэ гэсэн санаа бол *гурван бүрэлдэхүүнт* гэдэг нь нийгмийн халамж нь а) улсын тусламж, б) буяны өглөг, в) даатгал гэсэн бүрэлдэхүүнтэй байна. Харин *гурван зарчим* гэдэг нь халамж нь өөрийн зарчим, үйлчилгээ механизмтай байх ёстой гэж үзээд а) шударга, б) үр ашигтай, в) хөдөлмөрийн үйл ажиллагаанд түлхэц өгөхүйцээр зохион байгуулагдахыг хэлнэ<sup>51</sup> гэжээ.

Нийгмийн халамж хэмээх ойлголтыг судлаачид болон олон улсын байгууллагууд хэрхэн тодорхойлсоныг авч үзье.

*Хүснэгт 2. “Нийгмийн халамж”-ийн тодорхойлолтууд*

Тодорхойлолт	
<b>Маргарет Грош, Карло дел Нинно, Эмил Теслиук, Азедин Оуэргхи</b>	Нийгмийн халамж болон нийгмийн халамжийн тусламж гэдэг нь хүн амын ядуу, эмзэг бүлгийнхэнд тэднээс хувь шимтгэл шаардахгүйгээр буцалтгүй олгож байгаа тусламжийг хэлнэ <sup>52</sup> .
<b>Азийн хөгжлийн банк (ADB)</b>	Нийгмийн халамжийн тусламж гэдэг нь нийгмийн хамгийн эмзэг бүлгийн өрх, иргэн, олон нийтэд тэдний наад захын хэрэгцээг хангах, амьдралын чанарыг сайжруулахын тулд боловсруулсан хөтөлбөрийг хэлнэ <sup>53</sup> .
<b>Их Британы Олон Улсын Хөгжлийн Яам (DFID)</b>	Нийгмийн халамжийн тусламж гэдэг нь ядуурал ба эмзэг байдлыг үндэслэн олон нийтээс тодорхойлсон бүлгийнхэнд тэднээс хувь шимтгэл шаардахгүйгээр буцалтгүй олгож байгаа тусламжийг хэлнэ. Үүнд боловсролын болон эрүүл мэндийн төлбөрөөс чөлөөлөх, сургуулийн хүүхдийн хоол, хүнсний дэмжлэг зэрэг багтана <sup>54</sup> .
<b>Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ILO)</b>	Нийгмийн халамжийн тусламж гэдэг нь орлого багатай хүмүүст үзүүлэх татвараас санхүүжигдэх тэтгэмжийг хэлнэ <sup>55</sup> .
<b>Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага</b>	Нийгмийн халамжийн тусламж гэдэг нь орлогын доод түвшинд байгаа өрхийг дэмжих, хүнд хэцүү нөхцөлд амьдарч байгаа хүмүүст туслах, нийгмийн гадуурхалтыг бууруулах, өөрөө

<sup>50</sup> Г.Оюунцэцэг, Ч.Дагвадорж (2003) *Нийгмийн халамжийн удирдлага*. УБ

<sup>51</sup> Мөн тэнд

<sup>52</sup> Маргарет Грош, Карло дел Нинно, Эмил Теслиук, Азедин Оуэргхи “Нийгмийн халамжийн үр дүнтэй тогтолцоо” УБ 2012 он

<sup>53</sup> Howell, Fiona. 2001. “Social Assistance: Theoretical Background”. In Isabel Ortiz, ed., *Social Protection in Asia and the Pacific*. Manila: Asian Development Bank

<sup>54</sup> DFID (Department for International Development). 2005. *Social Transfers and Chronic Poverty: Emerging Evidence and the Challenge Ahead*. DFID Practice Paper. London: DFID

<sup>55</sup> ILO (International Labour Office). 2000. *World Labour Report 2000: Income Security and Social Protection in a Changing World*. Geneva: ILO

	өөрийгөө авч явах чадавхийг нэмэгдүүлэхийн тулд үзүүлж байгаа тусламжийг хэлнэ <sup>56</sup> .
<b>Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллага (FAO)</b>	Нийгмийн халамж нь баялгийг дахин хуваарилах замаар ядуурлыг бууруулах, өрх бүлийг орлогын хомсдолоос сэргийлэх зорилгоор олгож буй мөнгөн болон мөнгөн бус тусламжийг хэлнэ. Нийгмийн халамж нь амьдралын наад захын хэрэгцээ болон хүнс тэжээлийн үндсэн хэрэгцээг хангах, өрх гэр бүлд эрсдэлээс өөрийгөө хамгаалахад нь туслах зорилготой <sup>57</sup> .
<b>Олон улсын валютын сан (IMF)</b>	Нийгмийн халамж гэдэг нь нийгэмд хийгдэж байгаа өөрчлөлтийн улмаас ядуу хүмүүст сэргөөр нөлөөлөх нөлөөллийг багасгахад чиглэсэн арга хэмжээг хэлнэ <sup>58</sup> .
<b>Ц.Бумхорол</b>	Нийгмийн халамж гэдэг нь хүн амын эмзэг хэсэгт хамрагдах ахмад настан, эх, хүүхэд, тахир дутуу хүн, нэн ядуу амьдралтай иргэнд тэтгэвэр, тэтгэмж олгох, хөнгөлөлт үйлчилгээ үзүүлэх чиглэлээр тэдний амьжиргааг дээшлүүлэх, түүнчлэн хүүхэд төрүүлсэн эх, бүтэн өнчин хүүхэд үрчлэн авсан эх (эцэг) болон ихэр хүүхдэд тэтгэмж олгох агуулга бүхий нийгмийн хамгааллын арга хэмжээ юм <sup>59</sup> .
<b>Ч.Дагвадорж</b>	Нийгмийн халамж гэдэг нь амьдралд тохиолдсон хүндрэл, бэрхшээлийн үед бие даан амьдрах чадвар сул, эрсдэлд өртөмтгий хүмүүсийн амьжиргааны нөхцлийг дээшлүүлэхэд нийгмээс материалын болон сэтгэл санааны бодит туслалцаа үзүүлэх, авъяас чадварыг нь хөгжүүлэх, дадал туршлагыг нь дэмжих, амьдралын итгэл үнэмшил олгоход чиглэгдсэн үйл ажиллагаа <sup>60</sup> .
<b>Нээлттэй нийгэм форум</b>	Нийгмийн халамж нь бие даан амьдарч өөрөө өөртөө үйлчлэх чадваргүй, төрийн зүгээс зайлшгүй туслалцаа дэмжлэг үзүүлэх шаардлагатай боловч даатгалын хуулиар тэтгэвэр тэтгэмж авах эрх үүсээгүй нийгмийн эмзэг бүлгийг төр ивээлдээ авч туслах шаардлагаас урган гарах нийгмийн хамгааллын арга хэмжээг хэлнэ. Мөн эдийн засгийн хувьд түр зуур хүнд байдалд орсон зарим иргэдэд (бүрэн ба бүрэн бус ажилгүйчүүд, суралцагчид гэх мэт) зайлшгүй чухал мэдээлэл, хөрөнгө, зээл олгох, сургалт явуулах, эрхийн хамгаалалт, хөнгөлөлт үзүүлэх зэргээр дэмжин туслах арга хэмжээний тогтолцоог ингэж нэрлэдэг <sup>61</sup> .
<b>Монгол улсын Нийгмийн халамжийн тухай хууль (2012)</b>	Нийгмийн халамж гэж эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хэлнэ <sup>62</sup> .

<sup>56</sup> Adema, Willem. 2006. *Social Assistance Policy Development and the Provision of a Descent Level of Income in Selected OECD Countries*. OECD Social Employment and Migration Working Papers No. 38. Paris: Organisation for Economic Co-operation and Development

<sup>57</sup> FAO (Food and Agriculture Organization). 2003. "Safety Nets and the Right to Food" Intergovernmental Working Group for the Elaboration of a Set of Voluntary Guidelines to Support the Progressive Realization of the Right to Adequate Food in the Context of National Food Security Information Paper. Rome: FAO.

<sup>58</sup> Chu, Ke-young, and Sanjeev Gupta (1998) "Economic reforms, social safety nets, and the budget in transition economies." In Ke-young Chu and Sanjeev Gupta, eds., *Social safety nets: Issues and recent experiences*, pp63-93. Washington, DC: International Monetary Fund

<sup>59</sup> Ц.Бумхорол (2000) *Нийгмийн бодлогын зарим асуудлууд*. УБ

<sup>60</sup> Ч.Дагвадорж (2004) *Нийгмийн хамгаалал: онол-арга зүй, туршлага, харьцуулалт*. УБ

<sup>61</sup> *Нээлттэй Нийгэм форум*, UNDP (2006) *Ардчилсан засаглал, нээлттэй нийгмийн нэр томъёоны тайлбар толь*, УБ

<sup>62</sup> *Нийгмийн халамжийн тухай хууль (2012)*

Нийгмийн халамжийг ойлголтынх нь хувьд нийгмийн шинжлэх ухаан, олон улсын байгууллагууд болон улс орнууд янз бүрээр тодорхойлсон байдаг ч өнчин хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настан, олон хүүхэдтэй, өрх толгойлсон эцэг/эх, орлого багатай өрх, иргэн зэрэг хүн амын зорилтот бүлэгт амьдралын бололцоо олгоход чиглэсэн дэмжих, туслах үйлчилгээг төрөөс үзүүлэх үйл ажиллагаа гэж тодорхойлох нь нийтлэг ажээ. Дээрх тодорхойлолтуудыг харьцуулан үзвэл дараах нийтлэг талууд ажиглагдаж байна. Үүнд нийгмийн халамж гэдэг нь:

1. Төрөөс үзүүлдэг үйлчилгээ;
2. Татварын орлогоор санхүүждэг;
3. Буцалтгүй олгож байгаа тусламж;
4. Даатгалын хуулиар тэтгэвэр, тэтгэмж, тусламж авах эрхгүй;
5. Амьдралын наад захын анхдагч хэрэгцээг хангахад чиглэсэн;
6. Хүн амын ядуу хэсэгт чиглэдэг;
7. Ядуу амьдралтайн дээр бие даан амьдрах чадвар султай хүн амын эмзэг хэсэг (хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настай, бүтэн болон хагас өнчин хүүхэд, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг/эх гэх мэт)-т туслах;
8. Өрх, иргэнийг эрсдэлээс хамгаалах зорилго бүхий үйлчилгээ гэж үзэх нь нийтлэг байна.

Дээрх тодорхойлолтуудад үндэслэн “нийгмийн халамж” гэсэн ойлголтыг дараах байдлаар тодорхойлох боломжтой. Үүнд: ***Нийгмийн халамж гэдэг нь ядуурлын нөхцөлд амьдарч байгаа, бие даан амьдрах чадвар сул өрх, иргэний амьдралынх нь наад захын хэрэгцээг хангах, улмаар ядуурлаас гаргахад дэмжлэг болох зорилгоор төрөөс үзүүлж буй буцалтгүй тусламж, тэтгэвэр, тэтгэмж болон бусад үйлчилгээ, үйл ажиллагааг хэлнэ.***

Нийгмийн халамж хэмээх ойлголтын зэрэгцээ “welfare state” буюу “халамжит төр” хэмээх ойлголт нийгмийн шинжлэх ухаанд түгээмэл хэрэглэгддэг. Судлаачдад хүлээн зөвшөөрөгдсөн ойлголтоор халамжит төр нь иргэдийнхээ сайн сайхан амьдрах эдийн засаг, нийгмийн баталгааг ижил тэгш боломжийн үндсэн дээр бүрдүүлэн ажиллаж буй төр юм. Халамжит төрийн Засгийн газрын гол үүрэг нь иргэдийн нийгэм, эдийн засгийн сайн сайхан байдлыг хамгаалах, дэмжих юм. Халамжит төр нь эд баялгийг нийгэмд тэгш хуваарилах зарчим дээр тулгуурладаг ба өөрсдийгөө хамгаалах чадваргүй иргэдийн наад захын сайн сайхан амьдралын баталгааг хангах ёстой.<sup>63</sup>

---

<sup>63</sup> [https://en.wikipedia.org/wiki/Welfare\\_state](https://en.wikipedia.org/wiki/Welfare_state)

Скандиновын хойгийн улс орнууд болох Норвеги, Швед, Финланд, Дани зэрэг нь халамжит төрийн бодлогыг хэрэгжүүлж буй улс орнуудын сайн туршлага болдог. Эдгээр улсууд татвараар цугларсан төрийн мөнгийг эрүүл мэнд, боловсрол, болон хувь хүнд шууд чиглэсэн үйлчилгээнд зарцуулдаг. Эндээс халамжит төр гэдгийг нийгмийн халамжийн тогтолцоог бүх нийтийн сайн сайхан байдлыг хангахад чиглүүлдэг улс гэж ойлгож болно. Иймэрхүү халамжийн бодлоготой улсуудыг холимог эдийн засагтай<sup>64</sup> гэж нэрлэх нь ч бий. АНУ-аас эхлээд төвлөрсөн эдийн засаг бүхий Куба улс ч ийм эдийн засагтай орнуудын тоонд багтдаг. Төр бодлогоороо баян ядуугийн хоорондын зааг ялгааг багасгахын тулд ийм арга хэмжээ авдаг бөгөөд холимог эдийн засгийг бүрдүүлж буй гол хөрөнгө нь баян чинээлэг хэсгийнхний орлогын албан татвар байдаг. Халамжит төрийн бодлого ялгаатай хэрэгжиж буй улсуудын 3 загварыг Данийн социологч Эспинг Андерсен тодорхойлсон байна.

1. Социал демократ бодлого бүхий улсууд иргэний харъяалал дээрээ суурилсан халамж, үйлчилгээг үзүүлдэг. Үүнд Катар, Кувейт, Арабын Эмират зэрэг улсууд багтах бөгөөд гадаадын иргэн, харъяалалгүй хүнд энэ үйлчилгээ хаалттай байдаг. Энэ бүлэгт мөн Скандинавын хойгийн орнууд ордог;
2. Консерватив бодлого бүхий улсууд нь төвлөрлийг сааруулах зарчим буюу нийгмийн даатгалын тогтолцоогоороо дамжуулан халамжийн бодлогоо хэрэгжүүлдэг. Энд Австри, Бельги, Франц, ХБНГУ зэрэг Европын улсуудыг нэрлэж болно;
3. Либерал бодлого бүхий улсууд нь чөлөөт зах зээлийг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлэхдээ халамжийг ядуурлыг бууруулах, иргэдийнхээ суурь хэрэгцээг хангахад чиглүүлдэг. Энэ ангилалд Австрали, Япон, АНУ, Канад зэрэг орнуудыг багтаадаг.

Эндээс дүгнэхэд **“нийгмийн халамж”** ба **“халамжит төр”** хэмээх хоёр ойлголт олон шинжээрээ төстэй боловч агуулгын хувьд ялгаатай ойлголтууд ажээ. Халамжит төр хэмээх ойлголт нь нийгмийн халамж гэсэн ойлголтоосоо илүү өргөн агуулга, цар хүрээтэй юм. Халамжит төрийн үйл ажиллагаа нь эрүүл мэнд, боловсрол, нийгмийн даатгал, нийгмийн халамж болон бусад үйлчилгээнүүдийг багтаахын зэрэгцээ, бүх нийтийн сайн сайхан байдалд илүү анхаардаг байна. Харин нийгмийн халамж нь ядуурлын шугамнаас доогуур өрх, иргэний наад захын амьдралын хэрэгцээг хангахад гол анхаарлаа чиглүүлдэг талаар өмнө авч үзсэн билээ.

Хэдийгээр ихэнх улс орнуудын нийгмийн халамжийн санхүүжилт нь төрөөс (улсын төсөв болон орон нутгийн төсөв) байдаг ч, ядуу буурай

---

<sup>64</sup> *Encyclopedia of Political Economy. Ed. Phillip Antony O'Hara. 1999*

болон хөгжиж буй орнуудад Засгийн газартай гэрээ байгуулсан Олон улсын байгууллагын албан ёсны тусламжаас санхүүжих хэлбэр түгээмэл байдаг. Мөн сүүлийн үед төрийн байгууллагын чиг үүргийг нийгмийн үйлчилгээний байгууллагуудаар (хувийн хэвшил, ТББ, иргэний нийгмийн байгууллага) гэрээлэн гүйцэтгүүлэх (contracting out) хандлага олон улсад бий болж байгаа бөгөөд эдгээрийн санхүүжилт нь татвар төлөгчдийн мөнгө байдаг учраас уламжлалт төрөөс үзүүлж буй нийгмийн халамжтай адил гэж үзэж болно. Тухайлбал өндөр хөгжилтэй болон хөгжиж буй зарим оронд халамжийн үйлчилгээг төрөөс хариуцдаг тогтолцоог хувьчлах стратегийг хэрэгжүүлж эхлээд байна. Англо-Саксоны гэж нэрлэгддэг орнууд болох Авсрали, Канад, Шинэ Зеланд, Их Британи, АНУ<sup>65</sup> болон бусад орнуудад нийгмийн салбарын хувьчлал эхлээд байна. Нийгмийн халамжийн үйлчилгээг төр хариуцдаг нийгмийн баримжаа бүхий уламжлалт тогтолцоотой Франц, Швед улсуудад ч нийгмийн салбарын хувьчлалыг дэмжих хандлага бий болоод байна<sup>66</sup>. Европын холбооны гишүүн орнуудад нийгмийн салбарын хувьчлал нийтлэг үзэгдэл болж “улсын болон хувийн хэвшлийн нийгмийн халамжийн холимог тогтолцоо”, “холимог эдийн засгийн халамж”<sup>67</sup> гэдэг ойлголтын талаар ярих болсон. Түүнчлэн Болгар, Чех, Унгар, Польш, Румын, Словак зэрэг хөгжиж буй орнууд нийгмийн салбарын хувьчлалыг ихээхэн сонирхож байна<sup>68</sup>. Нийгмийн халамжийн чанарыг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах, үйлчилгээг зохих хэмжээнд авч чадахгүй байгаа хүн амд үйлчилгээ хүргэх, үйлчилгээ үзүүлэх янз бүрийн стратегийг туршин хэрэгжүүлэх зэрэг олон шалтгааны улмаас Засгийн газрууд нийгмийн салбарын хувьчлалыг хэрэгжүүлдэг<sup>69</sup> байна.

Нийгмийн халамжийн хөрөнгийн эх үүсвэр нь цэвэр төрийн зүгээс зохицуулагддаг зүйл бөгөөд тухайн улсын төсвөөс шууд хамаарч байдаг. Татвар төлөгчдийн мөнгөөр халамжийн арга хэмжээ бүхэлдээ санхүүждэг. Энэ утгаараа нийгмийн халамжийг татвар төлөгч буюу орлогтой хэсгээс

---

<sup>65</sup> Paul Reed & Valerie Howe, *The Study of Voluntary Organizations in Ontario in the 1990s: A report to Participating Agencies, one in series of the Nonprofit Sector Knowledge Base Report, 1999*; Lawrence Martin, *Contracting for Service Delivery: Local Government Choices*. Washington, DC: International City/County Management Association, 1999; Department of Community Services, Government of New South Wales, Australia, *Purchasing, a Partnership Model, 1999*. <http://www.pandora.nla.gov.au/tep/31683>

<sup>66</sup> Johan Hjertqvist (1999) *Swedish Health-Care Reform: From Public Monopolies to Market Services*. Montreal Economic Institute

<sup>67</sup> Sheila Kameron & Al Kahn (1998) *Privatization, Contracting and reform of Child & Family social Services*. Washington, DC: The Finance Project, p. 9

<sup>68</sup> Caroline Newman (2000). “Comparative Study of NGO/Government Partnerships.” *The International Journal of Not-for-Profit Law* 2

<sup>69</sup> Lawrence Martin (1999) *Contracting for Service Delivery: Local Government Choices*. Washington, DC: International City/County Management Association

өөрсдийгөө тэжээх чадваргүй хэсэгт оруулж буй мөнгөн шилжүүлэг гэж хэлж болно.

Нийгмийн халамжийн тодорхойлолтуудад гарч буй нийтлэг ойлголт нь “ядуурал” юм. Өөрөөр хэлбэл нийгмийн халамж юуны өмнө ядуу иргэн, өрхөд чиглэх ба тэдний эн тэргүүний хэрэгцээг хангах, тэдэнд туслах дэмжих арга хэмжээ авдаг төрийн үйл ажиллагаа юм. Тиймээс ядуурал хэмээх ойлголтыг тодорхойлох нь асуудлыг цогцоор ойлгоход тустай. Ядуурлын талаар судлаачид өргөн хүрээтэй хэлэлцүүлэг өрнүүлж, түүнийг янз бүрийн тал, өнцгөөр тодорхойлж ирсэн байдаг.

Ядуурлыг голдуу амьжиргааны доод түвшингээр тодорхойлдог. Чарльз Бут туйлын ядуурлын үед амьжиргааны доод түвшин, өөрөөр хэлбэл үүнээс доош орвол хүний биет оршихуйг хангах үндсэн хэрэгсэл үгүй болох буюу хүнс, байргүйгээр хүний организм хэвийн ажиллах боломжгүй болох тийм заагийг үндэслэж ядуурлыг тогтоохыг оролдсон байдаг. Ийм хэрэгцээ нь амьдарч байгаа улс орноос үл хамааран тодорхой насны болон ойролцоо бие бялдартай хүмүүсийн хувьд ямар нэг хэмжээгээр адил байх ёстой гэж тэрээр үзэж байв. Энэхүү баримтлалыг ядуурлыг шинжлэхэд дэлхий нийтээрээ өнөөг хүртэл голлон ашиглаж байна<sup>70</sup>. Ийнхүү туйлын дорд байдлаар ядуурлыг тодорхойлж байхад зарим эрдэмтэд харьцангуй утгаар нь тодорхойлох нь ч байна. Тухайлбал Их Британийн эрдэмтэн Питер Таунсенд ядуурлыг тухайн нийгэмд ердийн буюу нийтээр хүлээн зөвшөөрсөн оршихуйн тав тухыг хангах боломжгүй нөхцөл гэж үзсэн байна<sup>71</sup>. Тэрээр энэ тодорхойлолтыг ашиглан Их Британичуудын талаас илүү хувь нь амьдралынхаа аль нэг үе шатанд (ялангуяа хөгшрөх үедээ) ядууралтай тулгардаг гэдгийг тооцож гаргасан байна. Ядуучуудын бүлэгт дараах хүмүүс, тухайлбал алдаг оног ажилладаг хүмүүс, ажилгүй хүмүүс, ахмад настангууд, өвчтөн, тахир дутуу хүмүүс, олон гишүүнтэй гэр бүл зэрэг нь юуны өмнө орох магадлалтай гэж үзсэн. Таундсендыг ядуурлын талаарх ойлголтыг хэтэрхий өргөн утгаар буюу харьцангуй байдлаар хэргэлсэн гэж шүүмжилдэг.

Ийнхүү ядуурлыг “туйлын ядуурал” болон “харьцангуй ядуурал” гэж үнэлэх дээрх хандлагуудаас гадна, ядуурлыг “чадамж ба үйл ажиллагаа”, “боломж” зэрэгтэй холбон өвөрмөц байдлаар тодорхойлсон хүн бол Нобелийн шагналт, эдийн засагч Амартия Сен юм. Тэрээр “Ядуурал гэдэг бол хүмүүсийн амжилттай ажиллах, оршин байх асуудал буюу чадамж ба үйл ажиллагааны хязгаарлалт болохоос бараа, үйлчилгээ авч чадахгүй байгаа явдал биш”<sup>72</sup> гэж үзсэн байна. Мөн тэрээр ядуурал

---

<sup>70</sup> Гидденс.А (2006) Социологи

<sup>71</sup> Townsend P (1979) *Poverty in the United Kingdom: A Survey of the Household Resources and Standart of Loving*. Harmondsworth

<sup>72</sup> Амартия Сен (2014) *Хөгжил бол эрх чөлөө*. УБ.Орчуулагч А.Энхбаатар

нь доогуур орлоготой байгаагаас бус суурь боломжууд үгүйгээс улбаатай гэж нотлохын зорьсон байдаг. Хувь хүний давуу талуудыг үнэлэхдээ нөөц боломжуудаас, өөрөөр хэлбэл, тухайн хүний санаанд нь үнэхээр багтаад байгаа тийм байдлаар амьдрал ахуйгаа авч явахад хэрэг болох суурь эрх чөлөөнүүдээс эхлэх ёстой. Ядууралд ингэж хандвал, ядуурлыг тодорхойлох хэвшмэл шалгуур болох орлого бага байх төдий биш, суурь боломжийн хомсдол гэж үзэх ёстой болно. Тухайлбал орлого болон боломжуудын хоорондын холбоонд хувь хүний нас, хүйс, нийгмийн үүрэг, амьдарч буй орон нутаг, халдвар зүйн нөхцөл байдал зэрэг хүний эрхшээлд үл орших хүчин зүйлс ноцтой нөлөөлдөг гэж үзсэн байна.

Гадны эрдэмтэд судлаачид төдийгүй дотоодын судлаачид ядуурлын асуудалд багаггүй анхаарч, түүнийг шинж байдлыг тодорхойлсон нь цөөнгүй байдаг. Тухайлбал “Дунд орлоготой хүмүүсийг эмзэг бүлгийн эгнээнд орохоос урьдчилан сэргийлэх арга замууд” сэдэвт судалгаанд “ядуу” гэдэг ойлголтыг дараах байдлаар тодорхойлжээ<sup>73</sup>.

- Орлого: Нэг сард ногдох орлого нь ядуурлын шугамнаас доогуур өрхүүд;
- Үл хөдлөх хөрөнгө: Өөрийн орон байргүй, түрээсийн болон дотуур байранд амьдардаг, эсвэл орон байрны нөхцөл хүндэвтэр өрхүүд;
- Хөдлөх хөрөнгө: Наад захын хэрэглээний цахилгаан хэрэгсэл болон эд зүйлс дутмаг, хөдөөгийн өрхөд бол малын тоо толгой хэт цөөн (70-аас доош), өрхүүд;
- Боловсрол, нийгэмд эзлэх байр суурь: Өрхийн гишүүдийн боловсролын түвшин доогуур, дээд боловсролтой нэг ч гишүүнгүй, өрхийн гишүүд байгууллагын дунд доод шатны ажил эрхэлдэг;
- Нийгэм эдийн засгийн өөрчлөлтөнд дасан зохицох чадвар: Ахуй амьдралд гарч буй өөрчлөлтүүдийг хүлээн авахдаа тааруу, бусдаас хамааралтайгаар амьжиргааны түвшингээ үнэлдэг, эрсдэлтэй тулгарсан үед ямар нэг оновчтой хариу үзүүлэх чадваргүй, дасан зохицох чадвар муутай өрхүүд.

Ийнхүү ядуурлыг олон талаас нь тодорхойлж авч үздэг байна. Ядуурлыг нийтлэг хандлагын үүднээс авч үзвэл хувь хүний аж байдлын доройтол, хомсдолтой байдлаар илрэх бөгөөд эрүүл мэнд, боловсрол, оюуны болон биеийн чадавхи доройтох, хоол тэжээлийн хомсдол, бараа үйлчилгээний дутагдалд орох, дэд бүтцийн үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал байх, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх чадвар хангалтгүй байх зэрэг юм. Ядуурлын талаарх туйлын (абсолют), харьцангуй гэсэн хоёр ойлголт байдаг. Туйлын ядуу гэж амьжиргааны наад

---

<sup>73</sup> Санхүү эдийн засгийн яам, НҮБХХ (2004) Дунд орлоготой хүмүүсийг эмзэг бүлгийн эгнээнд орохоос урьдчилан сэргийлэх арга замууд

захын зайлшгүй хэрэглээнээс доогуур хэрэглээтэй хүн амыг хэлдэг бол харьцангуй ядуу гэж тухайн хүн өөрийн хэрэгцээгээ хэрхэн үнэлж, бусадтай харьцуулж байгаагаар буюу хэрэгцээгээ өөрийн нөөц боломжтойгоо уялдуулан харьцуулж гаргасан дүгнэлтээр ядуу гэж тодорхойлж байгааг хэлнэ. Туйлын ядууралд амьжиргааны наад захын зайлшгүй хэрэгцээг голлон судалдаг бол харьцангуй ядуурал нь орлого, баялгийн хуваарилалт болон ядуучуудыг нийгмийн бусад бүлэг, давхрагатай харьцуулан судалдаг.

Монгол улсын төрөөс хүн амын амьжиргааны түвшин, ядуурлын байдлыг тооцохдоо хөгжиж буй орнуудад өргөн хэрэглэгддэг туйлын ядуурлаар тооцож тодорхойлдог. Монгол улсад ядуурлыг ҮСХ албан ёсоор тодорхойлдог ба хоёр жил тутамд Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа хийж, ядуурлын түвшинг тодорхойлж байна. Нийгмийн халамжийн зорилтот бүлгийн эн тэргүүний шалгуур нь “ядуу” гэсэн шинж учраас ядуурал гэсэн ойлголтыг дэлгэрэнгүй авч үзэх зайлшгүй шаардлагатай.

**Нийгмийн халамжийн үүрэг.** Нийгмийн халамж нь ядуурлыг бууруулах болон улс орны хөгжлийн бодлогод дараах үндсэн чиг үүргүүдийг гүйцэтгэдэг. Үүнд:

- 1. Ядуурлыг бууруулах.* Нийгмийн халамжийн арга хэмжээ нь бүхэлдээ ядуурлыг бууруулах чиг агуулгатай байдаг. Тэр дундаа туйлын ядуу болон эмзэг байдалд хариу өгөхөд чиглэдэг. Улс орнуудад явагдаж байдаг халамжийн нийт арга хэмжээ нь бүхэлдээ үндэсний ядуурлыг бууруулах, түүнийг даамжруулахгүй байлгахад чиглэдэг юм. Нийгмийн халамж нь хүн амын эмзэг болон нэн ядуу хэсэгт орлогыг дахин хуваарилах замаар ядуурал, тэгш бус байдлыг арилгахад нөлөөлөх үүрэгтэй.
- 2. Амьдралын наад захын баталгааг хангах.* Халамжийн маш чухал үүрэг бөгөөд хүний амьдралын хамгийн наад захын жишиг нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хэрэгждэг. Хоол, хувцас, орон байр бол хүний амьдралын наад захын жишиг гэж үзвэл улс орнуудын халамжийн тогтолцоо нь хоолны талон, түлшний хөнгөлөлт, асрамжийн газар, хоноглуулах байр, өдөр өнжүүлэх төвүүд, түүнчлэн өдөр тутмын хэрэгцээг хангахад чиглэсэн мөнгөн тэтгэмжүүдийг хэлж болох юм. Хүн гэгч нь хүнийхээ хувьд нэгэн нэр төртэй, хүн ёсны амьдралын нөхцөлөөр хангагдах учиртай гэсэн шашны болон хүмүүнлэгийн итгэл үнэмшил нь өдгөө зарим орнуудын хууль тогтоомжид тусгагдсан байдаг.
- 3. Нийгмийн халамж нь өрх гэр бүлд ирээдүйдээ хөрөнгө оруулах боломж олгох.* Энэ үүргийнхээ хүрээнд нийгмийн халамж нь санхүүгийн зах зээлээс авч чадахгүй байгаа боломжийг бага ч

- болов орлож, өрхийн амьжиргаандаа хөрөнгө оруулахад нь тусалдаг.
4. *Нийгмээс гадуурхагдсан (social exclusion) хэсгийг нийгэмд нэгтгэх буюу интеграцчилах.* Халамжийн үйлчилгээ нь нийгмийн бүлгүүдийн хоорондох интеграцчилалыг дэмжих зорилготой байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, оюуны хомсдолтой хүмүүс, үндэстний болон угсаатны цөөнх, шилжин ирэгсэд болон цагаачид, ядуус, одой хүмүүс нийгмийн харилцааны гадна үлдэж, нийгмийн хөгжлийг бүтээлцэхэд ч, түүний үр шимээс хүртэхэд ч тэр ямар нэг байдлаар гадна үлдсэн байх явдлын эсрэг нийгмийн халамж, тусламжийн арга хэмжээ чиглэдэг гэж хэлж болно.
  5. *Үйлчилгээнд хамруулах.* Нийгмийн харилцаанд бие даан оролцох чадваргүй хүмүүс нь тэр бүр ядуурлаас үүдэлтэй байдаггүй бөгөөд бие бялдар, сэтгэхүйн болон оюуны хөгжлийн хувьд бусдаас доогуур, эсвэл эмгэг өвчлөлтөөс үүдэлтэй байдаг. Ийм бүлэг хүмүүст мөнгөн тэтгэмжээс гадна үйлчилгээнд хамрагдах шаардлага зайлшгүй юм. Нийгмийн халамж, тусламжийн иймэрхүү үйлчилгээний тогтолцоог төр бий болгодог бөгөөд төрлүүдийн хувьд нөхөн сэргээх, нийгмийн болон сэтгэлзүйн засал, нийгэм сэтгэлзүйн зөвлөгөө, чадваржуулалт, хямралын интервенц, зуучлах, холбох гэх мэт байдаг.
  6. *Аюулгүй байдлыг хангах чиг үүрэг.* Нийгмийн халамж нь өрх гэр бүлийг эрсдлээс хамгаалах үүрэгтэй. Нийгмийн халамж нь өрх гэрийн амьжиргааны үндэс болсон гэр орон, аж ахуйгаа хүнд хэцүү цагт авч үлдэх, хүүхдүүдээ сургуульд хамруулах, тэжээн тэтгэх зэрэгт тусламж болдог. Үүгээрээ нийгмийн халамж нь өрх гэрийг эрсдлээс хамгаалан тэдний бие даасан байдлыг дэмжиж байдаг. Нийгмийн халамжийн тусламжийн зарим төрлүүд нь тусламж, дэмжлэг шаардлагатай хэсгийнхний амь нас, сэтгэлзүй, эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байлгахад чиглэдэг. Хүчирхийллийн дор байгаа хүүхэд, эмэгтэйчүүд болон бусад хүмүүс, амиа хорлохыг завдагсад, гүнзгий хямралд байгаа хүмүүс, биеийн өдөр тутмын хөдөлгөөнийг аюулгүй байдлаар хийж чадахгүй хүмүүс, өлсөж болон хөлдөж үхэх аюултай хүмүүс гэх мэтийн өмнө нийгмийн халамжийн аюулгүй байдлын чиг үүрэг хэрэгжих учиртай. Түүнчлэн мансуурах донгийн аль нэг төрөлд автсан хүмүүст (архаг архичид, хар тамхинд донтогчид, бусад донтнууд) үзүүлэх үйлчилгээ нь аюулгүй байдлын агуулгатай.
  7. *Нийгмийн эмзэг бүлгийг хөдөлмөрийн зах зээлд гаргах.* Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих буюу хөдөлмөрийн идэвхитэй бодлогын зарим арга хэмжээнүүд нь нийгмийн эмзэг хэсгийг хөдөлмөрийн зах зээлд

гаргах зорилготой байдаг ба энэ утгаараа халамжийн агуулгатай байдаг.

8. *Нийгмийн халамж нь үр өгөөж, өсөлтийг дэмжин ажиллах боломжийг Засгийн газарт олгох үүрэгтэй.* Нийгмийн халамжийн зохистой, тогтвортой тогтолцоо нь нийгэмд шаардлагатай байгаа дахин хуваарилалтыг хийснээр бусад салбарыг энэ үүргээс чөлөөлдөг.

Нийгмийн халамжийн тогтолцоо нь төрөөс баримталж байгаа нийгмийн бусад бодлоготой харилцан холбоотой, тэдгээр нь өөр хоорондоо нягт уялдаатай хөтөлбөрүүдээс<sup>74</sup> бүрддэг байх нь чухал. Нийгмийн халамжийн зөв тогтолцоо нь дараах шинж чанарыг агуулдаг байна<sup>75</sup>. Үүнд:

- Нийцтэй байх.
- Хүртээмжтэй байх
- Тэгш шударга хуваарилах.
- Үр ашигтай байх..
- Бэлэнчлэх сэтгэлгээ бий болгохгүй байх.
- Тогтвортой үргэлжлэх боломжтой байх.
- Динамик байх.

## ДҮГНЭЛТ

Төрийн бодлого, нийгмийн бодлого, нийгмийн хамгаалал, нийгмийн халамж хэмээх ойлголтууд нь ерөнхийгөөс нэгжрүү шилжих дараалал бүхий маш нарийн уялдаа холбоотой ойлголтууд юм. Тиймээс эдгээрийн уялдаа холбоог хангахад анхаарч ажиллах явдал туйлын чухал. Нийгмийн ажил нь хүнд туслахуйн практик мэргэжил, харьцангуй бие даасан, олон салбар чиглэлд нийт хүн амын сайн сайханд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг билээ. Энэ өгүүллийн хүрээнд төрөөс зорилтот бүлгийн иргэдэд үзүүлэх нийгмийн халамж нь нийгмийн ажлын арга зүйд тулгуурлах, нийгмийн ажлын мэргэжилтнүүдийн оролцоотойгоор илүү бодитой, үр дүнтэй хэрэгжих үндэстэй гэж дүгнэж байна.

Нөгөө талаар нийгмийн хамгаалал хэмээх өргөн ойлголтын хүрээнд нийгмийн халамжийн хил хязгаарыг зөв тодорхойлох шаардлага байна. Үүний тулд төрөөс зайлшгүй халамж үзүүлэх шаардлагатай иргэдийн эрх ашгийг хөндөхгүй байх ёстой. Нийгмийн халамж нь улс төрийн популист

---

<sup>74</sup> *Нийгмийн халамжийн хөтөлбөр гэдэгт нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөр, халамжийн үйлчилгээ гэх мэт төрөл бүрийн арга хэмжээг багтааж ойлгоно.*

<sup>75</sup> *Маргарет Грош, Карло дел Нинно, Эмил Теслук, Азедин Оуэргхи “Нийгмийн халамжийн үр дүнтэй тогтолцоо” УБ 2012 он*

амлалтыг хэрэгжүүлэгч механизм биш, бас популизмыг шүүмжлэгчдийн бай биш гэдгийг нийгэм олон нийтэд зөв ойлгуулахын тулд шинжлэх ухааны түвшинд эдгээр ойлголтуудыг хэрхэн авч үздэг талаар системтэй ойлголт бий болгох шаардлага байна. Ямарч өндөр хөгжсөн улс оронд нийгмийн халамж тодорхой хэмжээнд байдаг ба аливаа төр иргэдийнхээ нийгмийн баталгааг хангах үүрэгтэй байдаг.

### **НОМ ЗҮЙ**

- [1]. Anderson, James E. (1994) *Public policymaking*. New Jersey: Houghton Mifflin.
- [2]. Jochen, Clasen (2004) *Defining comparative social policy*. In Kennet Patricia A *Handbook of Comparative Social Policy*, Edward Elgar Publishing.
- [3]. С.Түмэндэлгэр (2002) *Нийгмийн ухааны зарим нэр томъёоны тайлбар*, УБ
- [4]. Н.Наранчимэг, П.Увш, Н.А.Волгин (2009), *Нийгмийн бодлого*, УБ.
- [5]. НХХЯ, ХХҮГ (2008), *Нийгмийн ажилтны сургалтын гарын авлага*, УБ,
- [6]. Нээлттэй Нийгэм форум, UNDP (2006) *Ардчилсан засаглал, нээлттэй нийгмийн нэр томъёоны тайлбар* толь, УБ
- [7]. Г.Оюунцэцэг, Ч.Дагвадорж (2003) *Нийгмийн халамжийн удирдлага*. УБ.
- [8]. Ч.Дагвадорж (1993) *Социальная защита населения в условиях рыночных отношений*. Диссертация на соискание учёние степени кандидата экономических наук. Москва.
- [9]. Ч.Дагвадорж (2004) *Нийгмийн хамгаалал: онол-арга зүй, туршлага, харьцуулалт*. УБ.
- [10]. United Nations Research Institute for Social Development (2010). *Combating Poverty and Inequality: Structural Change, Social Policy and Politics*.
- [11]. World bank (2001) *Social Protection Sector Strategy Paper: From Safety Net to Springboard*. Washington DC, USA
- [12]. Нээлттэй Нийгэм форум, UNDP (2006) *Ардчилсан засаглал, нээлттэй нийгмийн нэр томъёоны тайлбар* толь, УБ
- [13]. Ц.Бумхорол (2000) *Нийгмийн бодлогын зарим асуудлууд*. УБ.
- [14]. *Нийгмийн хөгжлийн төв, УБИС-ийн НА тэнхим (2002) Нийгмийн хөгжлийн хандлагатай нийгмийн ажил. Нийгмийн ажлын багш нарын зуны сургалтын материал.*
- [15]. Маргарет Грош, Карло дел Нинно, Эмил Теслиук, Азедин Оуэргхи “*Нийгмийн халамжийн үр дүнтэй тогтолцоо*” УБ 2012 он.
- [16]. *Нийгмийн халамжийн тухай хууль (2012)*.
- [17]. Гидденс.А (2006) *Социологи*
- [18]. Амартя Сен (2014) *Хөгжил бол эрх чөлөө*. УБ.Орчуулагч А.Энхбаатар.
- [19]. Санхүү эдийн засгийн яам, НҮБХХ (2004) *Дунд орлоготой хүмүүсийг эмзэг бүлгийн эгнээнд орохоос урьдчилан сэргийлэх арга замууд*. Судалгааны тайлан.